**МОНГОЛ УЛС**
**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2021 оны 04 сарын 21 өдөр | Дугаар А/270 | Номгон

Халаалтын үйл ажиллагааг зогсоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.4 /д/ дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.8 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст (Ковид-19) цар тахлын халдвар томуу, томуу төст өвчний өвчлөл, тархалтын улмаас Монгол Улсын 2021 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэх зорилгоор сумдын эрүүл мэндийн төв, аймгийн нэгдсэн эмнэлгийн барилгын халаалтаас бусад байгууллагууд, хэрэглэгчдийн халаалтыг говийн (Өлзийт, Баян-Өндөр, Шинэжинст, Баянцагаан, Богд, Жинст, Баянлиг, Баянговь, Баацагаан) сумд 2021 оны 04 дүгээр сарын 25, аймгийн төв болон хангайн (Баянхонгор, Эрдэнэцогт, Галуут, Заг, Жаргалант, Гурванбулаг, Баянбулаг, Бууцагаан, Хүрээмарал, Баян-Овоо, Бөмбөгөр) сумд 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдөр халаалтын үйл ажиллагааг зогсоохыг дулаан үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын дарга, захирал нарт тус тус даалгасугай.

2.Дээрх ажлыг зохион байгуулж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн гишүүн (Д.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

621010679